



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/116

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.1.6 /г/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 4 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бүгд Найрамдах Франц улсын Парис хотноо зохион байгуулагдах "Монголын соёлын өдөр" арга хэмжээнд Монгол улсаа төлөөлөн оролцохоор шалгарсан аймгийн ТХДЖТ-ын хөгжимчин, морин хуурч Цогтбаярын Мөнх-Эрдэнэд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 1.000.000 /Нэг сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА О БАТ – ЭРДЭНЭ

0200378